

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.....

Б. БЯМБАДОРЖ

БАТЛАВ:

ЧИХ, ХАМАР, ХООЛОЙ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА..... Э. ЖАРГАЛХҮҮ

НҮҮР, АМ СУДЛАЛЫН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА..... Л. ХЭНТИЙ

“ТОЛГОЙ, ХҮЗҮҮНИЙ МЭС ЗАСАЛ СУДЛАЛ”

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА: ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ИНДЕКС: S(s)0912/10/07

ХУГАЦАА: 1 ЖИЛ

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Ц. Одонтунгалаг, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын ахлах зэргийн эмч,

Д. Мөнхцэцэг, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын тэргүүлэх зэргийн эмч

Г. Ариунбаатар, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын тэргүүлэх зэргийн эмч

С. Денис, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын тэргүүлэх зэргийн эмч

Б. Батцэнгэл, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын эмч

Б. Ган-Эрдэнэ, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын эмч

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Г. Пүрэвдорж, Хавдар судлалын үндэсний төвийн Толгой хүзүүний мэс заслын тасгийн эрхлэгч, хүний гавъяат эмч, тэргүүлэх зэрэгтэй, Анагаах ухааны магистр

Ц. Бадамсүрэн, Хавдар судлалын үндэсний төвийн сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга, Анагаах ухааны доктор

П. Эрхэмбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны мэргэжилтэн

ХЯНАСАН:

Д. Баярмаа, Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн

Танилцуулга

Эрүүл мэндийн сайдын А184 дүгээр тушаалаар толгой хүзүүний мэс заслын нарийн мэргэшлийн сургалтын индекс батлагдсан. Уг сургалтыг улсын хэмжээнд толгой хүзүүний хавдрын мэс заслын үйлчилгээ үзүүлдэг Хавдар судлалын үндэсний төвийн толгой хүзүүний мэс заслын тасаг дээр төвлөрөн явуулна. Энэ мэргэшлээр анагаахын эмчилгээний ангийг дүүргэж мэс заслын аль нэг чиглэлээр нарийн мэргэшил эзэмшсэн (чих хамар хоолой, эрүү нүүрний мэс засал, нүдний мэс засал, ерөнхий мэс засал) эмч нар нарийсан суралцах ба нэг жилийн хугацаатай байна. Сургалтын хугацаанд толгой хүзүүний арван зургаан эрхтэний гажиг, хортой хоргүй хавдрын мэс заслын эмчилгээ болон эмчилгээний дараах ба гэмтлийн согогийг нөхөн сэргээх, яаралтай мэс заслын тусламжийн сургалтыг зургаан сэдэвчилсэн тойролтоор хийнэ.

Сургалтын хөтөлбөрийг тус тасгийн эмнэл зүйн сургагч багш - эмч болон бусад эмч нар тойролтод хуваан боловсруулсан ба Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтнээр гурван удаа хянуулан зөвлөгөө авч төгсгөлийн хувилбарыг хийлээ.

“ТОЛГОЙ, ХҮЗҮҮНИЙ МЭС ЗАСАЛ СУДЛАЛ”

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны тайлан мэдээгээр хорт хавдрын 1372 шинэ тохиолдол бүртгэгдсэнээс эмэгтэйчүүдийн 57%, эрэгтэйчүүдийн 74 хувь нь өвчний хожуу үе шатанд (III-IV) оношлогдон, хэвтэн эмчлүүлэгсдийн эрчүүдийн 82%, эмэгтэйчүүдийн 76% нь III-IV шатанд эмчлэгдсэн байна.

Дэлхий нийтэд толгой хүзүүний хорт хавдар тохиолдол, тархалтаараа нийт хавдрын 6-р байрт жагсдаг ба Монгол улсын хүн амын дундах хавдрын өвчлөлийн 7 дугаар байрт толгой хүзүүний байрлалтай хорт хавдрууд орж байна. Эдгээр хавдруудын ихэнх нь нүдэнд ил байрлалтай, эрт оношлох, бүрэн эмчлэх боломжтой. Манай улсад бусад хөгжилтэй орны жишгээр чих хамар хоолой судлалын сургалтын хөтөлбөрт энэ мэргэшил багтаагүйгээс энэ мэргэшлийн үйлчилгээг улсын хэмжээнд ганц эмнэлэгт буюу Хавдар судлалын үндэсний төвийн толгой хүзүүний мэс заслын тасагт үзүүлж байна. Эрх зүйн хувьд хоргүй хавдрын эмчилгээ үйлчилгээг II ба бусад III шатлалын эмнэлэгт үзүүлэх ёстой ч одоогоор нарийн мэргэшлийн мэс заслын эмч нар хангалттай бэлтгэгдээгүйгээс хоргүй хавдар болон бусад үрэвсэл, гажгийн оношлогоо эмчилгээнд үйлчлүүлэгчдийг хавдар судлалын төвийн мэргэжлийн ганц тасагт илгээсээр байна. Тухайлбал 2017 оны тус төвийн статистик мэдээгээр амбулаториор толгой хүзүүний мэс заслын кабинетуудад 9100 орчим үйлчлүүлэгч үйлчлүүлснээс 2110 нь хортой хавдар бусад нь хоргүй хавдар, хавдрын урьдал өвчний тохиолдол байсан байна.

2013 оноос богино хугацаагаар эмч нарыг энэ мэргэшлийн төрөлжсөн сургалтанд хамруулж байгаа ч сургалтын хугацаа богино, нарийн ур чадвар туршлага шаардагддаг болон өргөтгөсөн мэс засал хийх чадамжтай эмч нар хүртээмжтэй бэлтгэгдээгүй байна. Иймээс толгой, хүзүүний хавдар, булчирхай, үүсвэрийг илрүүлэх, оношлох; шаардлагатай эд, эсийн шинжилгээг авч ялган оношлох, тодорхой хүрээний төрөлхийн гажиг болон хоргүй хавдрыг авах чадамжтай эмч бэлтгэх шаардлага тулгарч байна. Ингэснээр толгой, хүзүүний байрлалын дийлэнх хорт хавдрын бус эмгэгийн ялган оношлогоо болон мэс заслын эмчилгээг орон нутаг, II ба бусад III шатлалын эмнэлгүүдэд хийж эхлэн, төвлөрөл буурч хавдар судлалын үндэсний төвийн толгой хүзүүний тасгийн үйл ажиллагаа судалгаа хийх, нотолгоонд суурилсан төрөлжсөн мэргэжлийн удирдамжаар хангах улсын лавлагаа төвийн үүргээ гүйцэтгэх боломж илүү бүрдэх юм.

Цаашид ил байрлалын хавдруудын эрт илрүүлэг, төгс эмчилгээний хувийг дээшлүүлснээр эрүүл мэндийн салбарын зардлыг бууруулж, хүн ардад үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэх шаардлагад нийцүүлэн, олон мэргэшлийн уулзвар болсон энэ салбарын эмч мэргэжилтэнг бэлдэх хэрэгцээнд тулгуурлан уг хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Эрхэм зорилго

Толгой хүзүүний байрлалын эмгэгүүдийн яаралтай болон төлөвлөгөөт, нөхөн сэргээх мэс заслын тусламжийг аль ч түвшний эмнэлэгт бие даан үзүүлж чадах цогц чадамжтай толгой хүзүүний мэс заслын эмч болгон бэлтгэх.

Гурав. Алсын хараа

Чих, хамар хоолой, эрүү нүүр, нүд судлал, ерөнхий мэс засал болон бусад мэс заслын сургалтуудыг дүүргэсэн эмч нар зөвхөн өөрийн салбараар тогтохгүй толгой хүзүүний байрлалд тохиолдох бүх хортой, хоргүй хавдрууд болон урьдал эмгэгүүдийг ялган таньж илрүүлэн, байгаа нөхцлийг зөв үнэлэн, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд өөрт байгаа нөхцөлд тохируулан цаг алдалгүй мэс заслын яаралтай тусламжийг үзүүлэх, нөхцлөөс хэтэрсэн тохиолдолд дараагийн шатны тусламжинд оновчтой илгээх мэдлэг, чадвар, хандлага бүхий цогц чадамжтай мэс заслын эмч байна.

Дөрөв. Сургалтын зорилт

Дараах чадамжуудыг эзэмшсэн эмч бэлтгэнэ:

1. Толгой хүзүүний байрлалд тохиолддог өвчин, эмгэгүүдийн шинж тэмдгийг таньж, ялган, шаардлагатай тохиолдолд трахеостоми, цус алдалтыг тогтоох яаралтай мэс ажилбарыг газар дээр нь хийх
2. Хортой, хоргүй хавдар тэдгээрийн урьдал эмгэгүүдийг таньж, онош тогтоох, эхний шинжилгээ, үзлэгийг байгаа багаж нөхцөлд тохируулан хийх
3. Эд, эсийн шинжилгээ авах, сорьцоо журмын дагуу илгээх, шинжилгээний хариуг уншиж ойлгон дүгнэлтийг дүрсийн болон бусад шинжилгээтэй харьцуулан гаргаж эмчилгээг шийдэх
4. Толгой хүзүүний гэмтлийг үнэлж, тухайн нөхцөлд тохируулан мэс заслын тусламжийг үзүүлэх, боломжгүйг нь өргөтгөсөн нарийн мэргэшлийн тусламж үзүүлэх боломжит эмнэлэгт цаг алдалгүй илгээх
5. Толгой хүзүүний хоргүй хавдрыг мэс заслаар эмчлэх
6. Толгой хүзүүний байрлалын хорт хавдрын онош батлагдсан тохиолдолд боломжит нөхцөлд мэс заслын эмчилгээг хийж, улсын бүртгэлд мэдээллийг зохих журмын дагуу илгээх, дээд шатлалын эсвэл нөхцөл дээгүүр эмнэлэгт өргөтгөсөн мэс заслын болон өвөрмөц эмчилгээнд илгээх
7. Мэс заслын дараах өвчтөний хяналт, эмчилгээний менежментийн ерөнхий зарчмыг мэдэж шаардлагатай үед хавдар судлаач, согог засалч, хэл судлаач, сэргээн засах, сэтгэл зүйч, хоол судлаач болон бусад мэргэшлийн эмч нартай хамтран ажиллах
8. Мэс заслын дараах болон бусад шалтгаанаар үүссэн толгой хүзүүний согог, эрхтэний үйл ажиллагааны алдагдлыг мэс заслаар засах, нөхөн сэргээх
9. Толгой хүзүүний хавдар, түүний эмчилгээний явцад болон дараа амьсгалах, хооллохоос гадна ярих, нийгмийн харилцаанд хэвийн оролцож амьдрах үйл алдагдсанаас, гоо зүйн талаас гарсан өөрчлөлтийн улмаас өвчтөнд үүсэх эмнэл

зүй болоод сэтгэл зүйн гэмтлийн онцлогийг ойлгон мэдэрч өвчтөн болон ар гэр, садан төрлийнхөнтэй нь хүндэтгэлтэй хялбар үгээр харилцах, зөвлөх, энэ талаар хяналтын бусад эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, тэдгээрт нарийн мэргэшлийн зөвлөмж өгөх

10. Хорт хавдрын эцсийн шатанд амьсгалах, хооллох, ярих болон гоо зүйн талаас гарах өөрчлөлтийн улмаас өвчтөний болон ар гэрийн амьдралын чанарт гарах өөрчлөлтийг ойлгон, тэдэнд нөхцөл байдлыг ойлгуулах, хэцүү байдлаас урьдчилан сэргийлэхэд туслах, дэмжих, хөнгөвчлөх тусламжийг бусад эмч нартай хамтран үзүүлэх
11. Өөрийн мэдлэг ур чадвараа хэрэгцээт сургалтад хамрагдан байнга дээшлүүлж анагаах ухааны хөгжлийн хурдтай хөл нийлүүлэн өөрийгөө хөгжүүлэх хүсэл, зоригтой, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглан өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадвар эзэмшин төлөвших
12. Эмнэлгийн бусад тасгийн эмч нар болон бусад эмнэлгийн эмч нартай мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцан хамтран ажиллах
13. Эмчийн ёс зүй болон хүний ёс зүйг эрхэмлэдэг, зөв хандлагатай, багаар ажиллах чадвартай, онолын мэдлэг сайтай мэргэжилтэн болох

Тав. Сургалтын арга зүй

5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Толгой хүзүүний байрлалтай арван зургаан бүлэг эрхтэний мэс заслын яаралтай болон төлөвлөгөөт эмчилгээ тусламжийг бүлэглэсэн зургаан тойролтоор эзэмшинэ.
- Сургалтын нийт хугацаа нэг жил байна.
- Нэг тойролтын хугацаа агуулга, сургалт эрхлэх хүчин чадлаас хамааран 8-10 долоо хоног байна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон долоо хоногийн үйл ажиллагаа хавсралтад буй эмнэл зүйн багшийн ажлын хуваарьтай уялдсан тойролтын хуваарийн дагуу явагдана.
- Хавдар судлалын үндэсний төвийн толгой хүзүүний мэс заслын тасаг уг сургалтыг эрхлэн явуулна. Үүнд амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, мэс заслын өрөө, боолтын өрөө, бүлгээр суралцах сургалтын танхим зэрэг газруудад сургалт явагдана.
- Хүүхдийн толгой, хүзүүний буюу эрүү нүүрний яаралтай мэс заслын тусламжийн мэдлэг чадварыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийн эрүү нүүрний мэс заслын тасагт, толгой хүзүүний гэмтлийн яаралтай мэс заслын тусламжийн мэдлэг чадварыг Гэмтэл согогийн үндэсний төвд тойролтоор сургана.

5.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл

Тайлбар: Тойролт бүрт суралцагч дараах эмнэл зүйн чадварыг эзэмшиж дадлагажина. Тойролт бүрийн хуваарьт агуулга буюу судлах өвчин эмгэг, хийж сурах гардан үйлдлийг жагсаасан бөгөөд Толгой хүзүүний хавдрын эмгэг судлал, ангилал,

дүрс оношлогооны мэдлэг, онцлог асаргаа сувилгааны болон бусад чадварыг тухайн тойролт тус бүрийн агуулгат багтаан үзэж эзэмшинэ.

- Өвчтөний биеийн ерөнхий эрүүл мэндийн байдал, одоогийн өвчний түүхийг нарийвчлан авч амьдралын, нийгмийн амьдралын болон удамшлын түүхээс уг өвчний шалтгаан нөлөөллийг олж тогтоон өөрт нь болон асран хамгаалагчид нь зөвлөгөө өгөх, мэс засал, хими туяа эмчилгээний түүх, асран хамгаалагчийн дэмжлэг, асаргааны боломж байдал, орон нутгийн эмчийн талаарх мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх
- Эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаторийн болон хэвтэн эмчлүүлж буй өвчтөнийг үзэж, оношилж эмчлэх явцдаа дараах шинж тэмдгүүд, өвчнийг таньдаг болж гардан үйлдлийг бие даан хийж туршлага хуримтлуулна.

5.2.1 Шинж тэмдэг (signs and symptoms)

Толгой хүзүүний үзлэгийг гүйцэтгэхдээ дараах шинжүүдийг таньж, ялгаж, шалтгааныг тогтоох, дараагийн онош батлах шинжилгээг оновчтой хийж сурах:

Шинж тэмдэг

1. Халуурах, шөнөөр хөлрөх, турах (B symptoms)
2. Амны хөндийд эмчилгээнд эдгэрэхгүй цагаан улаан өнгийн салстын өөрчлөлт, шарх гарах (White or red patches, ulcer in mouth)
3. Өвдөх: эмчилгээнд намдахгүй хоолой, залгиурын өвдөлт, чих уруу дамжсан өвдөлт (Persistent sore throat, earache)
4. Цус алдалт (bleeding)
5. Толгой хүзүүнд гарсан үүсвэр (lump or mass in head and neck area)
6. Саа саажил (numbness or weakness in head and neck area)
7. Хаван (swelling)
8. Амьсгал бачуурал, хяхтнаа, дуу сөөх (breathing problems, stenosis, stridor, hoarseness) буюу трахеостомын заалт шалгах
9. Амны хөндий, залгиур, хамрын хавдрын шинж: шүд сулрах, хиймэл шүд таарахгүй болох, ярих, залгих өөрчлөгдөх (persistent nasal congestion, changes in speaking, swallowing, chewing, loose teeth, dentures that no longer fit)
10. Хорт хавдрын мэс засал ба өвөрмөц эмчилгээний дараа үүсэж болох бүтэц, үйл ажиллагааны алдагдлыг таних, ойлгох, ялгах (structural and functional post treatment change in head neck area)

ТОЛГОЙ ХҮЗҮҮНИЙ ЭРХТЭНИЙ ЭМГЭГҮҮДИЙН СУРГАЛТЫН ТОЙРОЛТ

ТХ-ний нарийн мэргэшлийн мэс заслын аргуудад туслахаар оролцох, эмчийн зөвшөөрлөөр хяналтын дор бие дааж хийх мэс заслын нэр, хуваарийг тойролтын хуваариас харна.

Ажлын байрны сургалт (On the job training - OJT)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	2	8 цаг, долоо хоногт 1 удаа	Амбулатори	Эмнэлзүйн багш, сувилагч, өвчтөн
Ганцаарчилсан ба хяналтын тойрон үзлэг	2	1 цаг, өдөр бүр	Тасаг, боолтын өрөө	Эмнэлзүйн багш, бусад эмч, сувилагч, өвчтөн
Мэс засалд оролцох	1	Долоо хоногт 2 удаа, тохиолдлын үргэлжлэх хугацаагаар	Мэс заслын өрөө, боолтын өрөө	Эмнэл зүйн сургагч багш
Тойролтын хуваарьт заасан гардан үйлдэл хийх	2	Долоо хоногт 2 удаа	Боолтын өрөө, амбулатори, тасаг, мэс заслын өрөө	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч, сувилагч
Олон мэргэшлийн хавдрын зөвлөгөөнд оролцох (Tumor board)	4-8	Тохиолдол байгаа үед	Хурлын болон сургалтын танхим	Тухайн тохиолдлын хавдрын эмчилгээ, менежментийг шийдэх олон мэргэшлийн эмч нар

Танхимын сургалт (Off the job training - Off JT)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	4-8	Чөлөөт цагаар	Сургалтын өрөө, гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч
Лекц	4-8	7 хоногт 1-2 удаа 1 цаг	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар	Эмнэлзүйн сургагч багш, суралцагч эмч нар
Семинар	4-8		Сургалтын өрөө		Эмнэлзүйн сургагч багш,

		7 хоногт 1-2 удаа 1 цаг 30 мин		Слайд, проектор, самбар	суралцагч эмч нар
Журнал клуб	4-8	Сард 1 удаа	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, суралцагч эмч нар

1. Бамбай булчирхай эмгэг, хүзүүний анхдагч болон хоёрдогч хавдруудын тойролтын хуваарь: E04.1, 04.2, 05.1,05.2;D16-18, 34, 44.0, 44.6, 48.1, 21-23; C33, 43, 73, 75.4, 76, I88.8, C77; L04.0

Хугацаа: Найман долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засалд оролцох		Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засалд оролцох		
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Амбулаторийн үзлэг			
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц Семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Тасгийн эмч нарын зөвлөгөөнд оролцох		Журнал клуб
Бямба	Тасгийн боолт				

Тойролтын агуулга:

- Бамбай булчирхайн хавдрын ерөнхий ойлголт. Бамбай булчирхайн эмбриолог, мэс заслын анатоми
- Бамбай булчирхайн хавдрын эпидемиологи. Бамбай булчирхайн хавдрын шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал
- Бамбай булчирхайн хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан багажийн шинжилгээний хяналтын дор эсийн шинжилгээ авах техник, нэмэлт оношилгооны аргууд (хэт авиан шинжилгээ, цөмийн онош зүй, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Бамбай булчирхайн хортой хавдрын эмчилгээ (мэс засал, радио идэвхт йод, туяа эмчилгээ), хяналт
- Хүзүүний мэс заслын анатоми, тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизмын биологи

- Хүзүүний тунгалагийн булчирхайд үсэрхийлэлийг үзэх арга. (үзлэг, хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ, эсийн шинжилгээ авах техник, нээлттэй эдийн шинжилгээ авах)
- Хүзүүний тунгалагийн булчирхайд үсэрхийлсэн хавдрын эмчилгээний зарчмууд
- Анхдагч хавдар тодорхойгүй хүзүүний тунгалагийн булчирхай дахь үсэрхийллийн эмчилгээний зарчмууд.
- Хүзүү өвчилт: Robbins түвшин I ба V
- Хүзүү өвчилт: Robbins түвшин II III IV
- Хүзүү өвчилт: Robbins түвшин VI
- Иж бамбай булчирхайн хавдар
- Хүзүүний зөөлөн эдийн бусад хавдар (липома, хемодектома, невринома, г.м.)
- Залгиурын хажуугийн зайн (parapharyngeal space) хавдрууд
- Хүзүүний мэс заслын дараах хүндрэлүүд, эдгээрийн эмчилгээний зарчим
- Хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах нөхөн сэргээх мэс заслын ерөнхий ойлголт.

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
I Бамбай булчирхайн эмгэг		
1. Бамбай булчирхайн эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх	20	Бие дааж хийх
2. Бамбай булчирхайн үүсвэрээс багажийн хяналтын дор эсийн шинжилгээ авах	15	Бие дааж хийх
3. Бамбай булчирхайн мэс засалд оролцох	20	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
II Хүзүүний тунгалгийн булчирхайн эмгэг		
1. Хүзүүний тунгалгийн булчирхайн эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх	20	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
2. Хүзүүний тунгалгийн булчирхайн эмгэгээс багажийн хяналтын дор эсийн шинжилгээ авах	10	
3. Хүзүү өвчих мэс засалд оролцох	20	
III Хүзүүний зөөлөн эдийн бусад хавдар		
1. Хүзүүний зөөлөн эдийн хавдартай болон төрөлхийн гажигтай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх	10	Бие дааж хийх
2. Хүзүүний зөөлөн эдийн хавдар авах, гажиг засах мэс засалд оролцох	10	Бие дааж хийх, туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх

3	Хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах нөхөн сэргээх мэс засалд оролцох	5	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
---	--	---	--------------------------------------

2. Шүлсний булчирхайн эмгэгийн тойролтын хуваарь: D11; K11;C83, 85; D48; D16,18; C07, 08, 41, 47, 49; K09.2

Хугацаа: Долоон долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засалд оролцох		Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засалд оролцох		
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Амбулаторийн үзлэг			
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц Семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Тасгийн эмч нарын зөвлөгөөнд оролцох	Журнал клуб	
Бямба	Тасаг				

Тойролтын агуулга:

- Шүлсний булчирхайн эрүүл болон эмгэг физиологи. Шүлсний булчирхайн эмбриологи. Мэс заслын анатоми.
- Шүлсний булчирхайн эмгэгүүд ба ялган оношлогоо.
- Шүлсний булчирхайн эмгэгийн дүрс оношлогоо. (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Шүлсний булчирхайн хавдар ба эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан шинжилгээний хяналтын дор эсийн шинжилгээ авах техник.
- Том шүлсний булчирхайн хавдрын тархварзүй. Шүлсний булчирхайн хавдрын шалтгаант хүчин зүйл, хавдрын ангилал. Том шүлсний булчирхайн хавдрын мэс засал эмчилгээ.
- Жижиг шүлсний булчирхайн хавдрын тархварзүй. Шүлсний булчирхайн хавдарын шалтгаант хүчин зүйл, ангилал. Жижиг шүлсний булчирхайн хавдрын ялган оношлогоо ба мэс засал эмчилгээ.
- Шүлсний булчирхайн хортой хавдрын хавсарсан эмчилгээний аргууд, (Хими, туяа эмчилгээний ерөнхий ойлголт)
- Шүлсний булчирхайн хортой хавдартай өвчтөнийг хянах.
- Эрүүний ясны хавдарын ерөнхий ойлголт, эмбриолог, анатоми.
- Эрүүний ясны эмгэгүүд ба дүрс оношлогооны аргууд.
- Эрүүний ясны үрэвсэлт өвчнүүд ба мэс засал эмчилгээ.
- Эрүүний ясны гэмтэл ба мэс засал эмчилгээ

- Гавлын ясны гаж хөгжлүүд ба эрүү ясны гажиг түүний онцлог, эмчилгээний ерөнхий ойлголт.
- Эрүүний ясны хавдрууд, тэдгээрийн ялган оношлогоо.
- Эрүүний ясны анхдагч болон нэвчиж ургасан хортой хавдар түүний оношлогоо, эмчилгээний арууд.
- Эрүүний ясны согог ба түүнийг нөхөн сэргээх мэс заслын ерөнхий ойлголт.

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
I Шүлсний булчирхайн эмгэг		
1. Шүлсний булчирхайн эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх	20	Бие дааж хийх
4 Шүлсний булчирхайн үүсвэрээс хэт авиан багажийн хяналтын дор эсийн шинжилгээ авах	15	Бие дааж хийх
5 Шүлсний булчирхайн мэс засалд оролцох <ul style="list-style-type: none"> ○ Паротидэктоми ○ Эрүүн доорх шүлсний булчирхайг авах ○ Хэлэн доорх шүлсний булчирхайг авах, ранула (уйланхай) нээх, арилгах ○ Шүлсний булчирхайн гэмтлийн менежмент/цорго сэргээх ○ Шүлсний булчирхайн чулуу авах 	20	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
II Эрүүний ясны хавдар.		
1. Эрүүний ясны эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлт хийх.	20	Бие дааж хийх
2. Эрүүний яснаас эдийн шинжилгээ авах.	2	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
3. Эрүүний ясны хавдартай өвчтөний мэс засал эмчилгээнд оролцох.	10	Туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх

3. Хамар, хамрын дайвар хөндийн хавдар өвчнүүдийн тойролтын хуваарь: C11, 30, 31, 41, 47; 72.4; D02.3, 10.6;14, 16; 44.3; J33, 34;

Хугацаа: Найман долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 12:00	12:00 – 14:00	14:00 – 15:00	15:00- 17:00
Даваа	Ганцаар-	Амбулаторийн үзлэг				

	чилсан үзлэг					
Мягмар	Хяналтын тойрон үзлэг	Эмч нарын яриа	Мэс засалд оролцох	Бие даалт	Лекц, семинар	Сургалтын тойрон үзлэг
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Мэс засалд оролцох	Боолт хийх		Сургалтын тойрон үзлэг
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Мэс засалд оролцох	7 хоног бүрийн сургалтын тайлан	Лекц, семинар	Сургалтын тойрон үзлэг
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Эмч нарын зөвлөгөөнд орох, үйлчлүүлэгчдийн бэлтгэлийг хангах	Өвчний түүх нээх	Журнал клуб	Сургалтын тойрон үзлэг
Бямба	Тасгийн боолт					

Тойролтын агуулга:

- Хамар, хамрын дайвар хөндийн мэс заслын анатоми, үзлэг хийх/ битүүрэл, үнэрлэхүйн мэдрэл, эмгэг бүхий дууны өнгө ялгаж сурах/
- Хамар, хамрын дайвар хөндийн дүрс оношлогоо-рентген, хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ
- Хамар, хамрын дайвар хөндийн үрэвсэлт өвчнүүд, оношлогоо эмчилгээ
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын ерөнхий ойлголт. Ангилал, үе шат.
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын эпидемиологи, эмбриологи шалтгаан эмгэг жам
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүй.
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын эсийн ангилал, эс, эдийн шинжилгээ
- Хамар, хамрын дайвар хөндийн өвчтнийг оношлох, дүгнэлт гаргах эмчилгээний тактик боловсруулах.
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдруудын онцлог, ангилал, үсэрхийлэл
- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын эмчилгээ-дурангийн мэс засал, нээлттэй мэс засал, хорт хавдрын өвөрмөц эмчилгээ
- Хамар, хамрын дайвар хөндийн гажиг, гэмтэл болон бусад хавдрууд
- Хамар, хамрын дайвар хөндийн хоргүй болон бусад эмгэгүүдийн эмчилгээ, онцлог хүндрэлүүд
- Өнчин тархины хавдар- оношилгоо, онцлог, эмчилгээ

- Хамар, хамрын дайвар хөндийн хорт хавдрын өвөрмөц эмчилгээний дараах онцлогууд
- Хамар, хамрын дайвар хөндийн хавдрын мэс заслын дараах хүндрэлүүд, эдгээрийн эмчилгээний зарчим
- Хамар, хамрын дайвар хөндийн хавдрын мэс заслын дараах нөхөн сэргээх мэс заслын ерөнхий ойлголт

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

№	Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
1	Эс, эдийн шинжилгээ авах тоо	40 удаа	Бие дааж хийх
2	Хамрын цус алдалт тогтоох тоо	20 удаа	Бие дааж хийх
3	Мэс засал, туяа эмчилгээний дараах шархны боолт, сувилгаа	16-20 удаа	Бие дааж хийх
4	Хамар, хамрын дайвар хөндийн хавдруудын мэс засалд оролцох (дуран, лазер, нээлттэй мэс засал) <ul style="list-style-type: none"> • Хамрын тайралт, духны далбангаар нөхөн сэргээх • Латерал ринотоми, нүүрний дунд 1/3 сөхөх (midfacial degloving), алотоми • Хоншоорын тайралтууд (subtotal/total maxillectomy, medial maxillectomy) • Гавал-нүүрний (craniofacial) тайралтууд • Нармайн хавдар, гавлын суурийн мэс засал 	тохиолдол бүрт	Харах, туслах мэс засалчийн үүрэг гүйцэтгэх
5	Хоншоорын (maxillary) хөндийн нөхөн сэргээх мэс засалд оролцох	тохиолдол бүрт	Харах, туслах мэс засалч

Амны хөндийн эмгэгийн тойролтын хуваарь: C00-06, 14; D00, 03, 10, 18, 22, 37, K09.0-0.9.1, K09.8-09.9

Хугацаа: Долоон долоо хоног

Цаг Гаргаг	08:00-08:30	08:30-09:00	09:00-13:00	13:30-15:00	15:00-16:30
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг		
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх	Боолтын өрөөнд гардан ажилбар, боолт	

Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал	Лекц, семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх	Журнал клуб
Бямба	Тасгийн боолт			

Тойролтын агуулга:

- Амны хөндийн хорт хавдрын тухай ерөнхий ойлголт, мэс заслын анатоми, физиологи
- Амны хөндийн хорт хавдрын тархалт, шалтгаан, хүчин зүйлс
- Амны хөндийн хорт хавдрын урьдал өвчнүүд, түүний ангилал, эмнэл зүй, эмчилгээ
- Амны хөндийн хорт хавдрын эмнэл зүй /байрлал тус бүрээр/
- Амны хөндийн хорт хавдрын ангилал /байрлал, ургах хэлбэр, үе шат, эдийн ялгарлын зэрэг, эд, эсийн гарал, хавдрын хэмжээ, үсэрхийлэлийн хүрээ- TNM:tumor, node, metastases/
- Амны хөндийн хорт хавдрын орчны тунгалгийн булчирхай дахь үсэрхийллийн онцлог, хүзүүний тунгалгийн булчирхайн түвшнүүдийн тухай ойлголт
- Амны хөндийн болон жижиг шүлсний булчирхайн хоргүй хавдрууд, түүний эмнэл зүй, эмчилгээ
- Амны хөндийн хорт хавдрыг бусад өвчнүүдээс ялган оношлох (урьдал өвчин, шүлсний жижиг булчирхайн хавдрууд, сүрьеэ, тэмбүү, мөөгөнцөр гэх мэт өвөрмөц болон бусад өвөрмөц бус үрэвсэлт өвчнүүд, амны хөндийн хоргүй хавдрууд)
- Амны хөндийн хавдартай өвчтөнг үзэж оношлох, шинжлэх арга барил (асуумж , үзлэг, эс болон эдийн шинжилгээ авах арга техник, лабораторийн болон багажийн шинжилгээнүүд)
- Амны хөндийн хорт хавдрын эмчилгээ (мэс засал, туяа, хими, хэл засал, хоол судлал, физик эмчилгээ, сэтгэл судлал, эндокринолог)
- Амны хөндийн хорт хавдартай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх шатлал, хяналт, асаргаа, сувилгаа
- Амны хөндийн хорт хавдартай өвчтний хагалгааны дараах хүндрэл, түүний эмчилгээ
- Амны хөндийн хорт хавдрын өргөтгөсөн мэс заслын дараахь нөхөн сэргээх хагалгааны ерөнхий ойлголт
- Амны хөндийн хорт хавдрын үе шатаас хамааран анхдагч болон үсэрхийлсэн хавдарт хийгдэх мэс заслын эмчилгээний зарчим
- Амны хөндийн хорт хавдраас урьдчилан сэргийлэх, дахилтаас урьдчилан сэргийлэх нь
- Амны хөндийн байрлалтай хавдар болон хүзүүнд үсэрхийлэлтэй хавдрын заалтаар хийгдсэн хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ уншиж сурах (байрлал, анатоми, тархалт, үсэрхийлэл)

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
1. Уруул:		
1.1. Улаан хүрээ тайрах (vermillionectomy)	2	Туслах мэс засалч эмч
1.2. Шаантган тайралт \нөхөн сэргээлт	3-5	Туслах мэс засалч эмч
1.3. Дээд уруулын тайралт \нөхөн сэргээлт	3	Туслах мэс засалч эмч
1.4. Доод уруулын тайралт \нөхөн сэргээлт	3	Туслах мэс засалч эмч
2. Амны хөндий:		
2.1. Хэлний хэсэгчилсэн ба бүрэн тайралт (урд 2\3)	5	Туслах мэс засалч эмч
2.2. Хэлний хэсэгчилсэн ба бүрэн тайралт (хэлний уг)	3	
2.3. Амны ёроолын тайралтууд	10	
2.4. Доод эрүүний тайралтууд (ирмэгийн болон хэсэгчилсэн/ бүтэн)	2	
2.5. Мандибулотоми	3	
2.6. Доод эрүүнд ялтас тавих		
2.7. Шүд авах		
2.8. Зөөлөн\хатуу тагнайн мэс засал	3-5	Туслах мэс засалч эмч
2.9. Аман доторх нөхөн сэргээлт	5	Туслах мэс засалч эмч
2.10. Доод эрүүний нөхөн сэргээлт	3	Туслах мэс засалч эмч

5.Залгиур, төвөнхийн эмгэгийн тойролтын хуваарь: C09-10,12-15; J35, 36, 38, 39, D10, 14.1

Хугацаа: Долоон долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц, семинар
Мягмар	Ганцаарчил	Хамтар-	Амбулаторийн үзлэг		

	-сан үзлэг	сан тойрон үзлэг		
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх	Боолтын ерөөнд гардан ажилбар, боолт
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал	
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх, эмч нарын зөвлөгөөнд оролцох	Лекц Семинар
Бямба	Тасгийн боолт			

Тайлбар: Журнал клубыг сард 1 удаа хийх ба мэргэжлийн хурал, семинартай үед шинэ мэдээллүүдийг багцлан нэмж буюу нөхөж хийнэ.

Тойролтын агуулга:

- Амьсгал, хоол боловсруулах дээд замын ерөнхий болон топографи анатоми, түүнийг мэс засалд хэрэглэх- Төвөнх, Залгиур: Нармай, ам-залгиур, багалзуур идээт үрэвсэл болон хавдар тархах замууд, зайнууд
- Төвөнх, залгиурын физиологи, судлах шинжлэх аргууд, компьютерт томографийн шинжилгээ (тодосгогчтой, тодосгогчгүй), соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ-тодосгогчтой ба тодосгогчгүй, өөх дарангуйлсан, T1, T2 цонх
- Төвөнх, залгиурын гаж хөгжил, хавдрын бус эмгэгүүд
- Төвөнх, залгиурын хоргүй хавдар тэдгээрийг бусад эмгэгээс ялган оношлох
- Төвөнх, залгиурын хортой хавдар, ангилал, тэдгээрийг бусад эмгэгээс ялган оношлох
- Төвөнх, залгиурын эмгэгийн мэс заслын эмчилгээ, хөнөөл багатай болон өргөтгөсөн мэс заслууд, заалт, хүндрэлүүд
- Төвөнх залгиурын мэс заслын дараах согог, нөхөн сэргээх аргууд, хүндрэлүүд
- Төвөнх, залгиурын хорт хавдрын, хими туяа эмчилгээний заалт, эмчилгээний дараах хяналт. Олон мэргэшлийн хавдрын эмч нарын зөвлөгөөн (Tumor board)

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
4. Дуран:		
а. Нармай, төвөнх шууд дурандах (уян ба хатуу дуран)	Хатуу – 30 Уян – 10	Бие дааж хийх
1.1. Эдийн шинжилгээ авах (дурангаар нармай, төвөнхөөс ба ам-залгиураас багажаар)	Дурангаар – 10, залгиураас багажаар - 10	Бие дааж хийх
2. Төвөнх		
2.1. Төвөнх нээж (laryngofissure) дууны хөвч тайрах (chordectomy)	5	

2.2. Төвөнхийн дурангийн хэсэгчилсэн тайралт (дууны нугалаасны ба түүнээс дээшхи)		Туслах мэс засалчаар оролцох
2.3. Төвөнхийн хэсэгчилсэн тайралт	2	
2.4. Төвөнх бүтэн тайрах (total laryngectomy)	5	
2.5. Фаринголарингэктоми	Байгаа тохиолдол бүрт	
2.6. Цагаан мөгөөрсөн хоолой-улаан хоолойн шунт		
2.7. Утгуур мөгөөрс авах		
3. Залгиур, цагаан мөгөөрсөн хоолой, залгиурын хажуу зай		
3.1. Цагаан мөгөөрсөн хоолойг нээх (tracheotomy, tracheostomy)	5 5	Харах, оролцох Бие дааж хийх
3.2. Цагаан мөгөөрсөн хоолойн нарийсал засах, нөхөн сэргээх	Байгаа тохиолдолд	Харах, оролцох
3.3. Улаан хоолойн хүзүүний хэсгийг авах	Байгаа тохиолдолд	Харах, оролцох
3.4. Зенкерийн цүлхэн авах (дурангаар, нээлттэй аргаар)	Байгаа тохиолдолд	Харах, оролцох
3.5. Крикофарингеал миотомилмиозэктоми	Байгаа тохиолдолд	Харах, оролцох
3.6. Залгиурыг хэсэгчлэн болон бүтэн тайрах	Байгаа тохиолдолд	Харах, оролцох

5. Нүүр болон арьсны эмгэг нөхөн сэргээх тойролтын хуваарь: D03.1-03.4, 04, 17, 21- 23, L02, C43-44

Хугацаа: Долоон долоо хоног

	08:00 – 08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00	15:00 – 16:30
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг		
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх	Боолтын өрөөнд гардан ажилбар, боолт	
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Мэс засал		Лекц Семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хамтарсан тойрон үзлэг	Түүх нээх, шинэ өвчтөн үзэх, хагалгаанд бэлдэх, эмч нарын зөвлөгөөнд оролцох		Журнал клуб
Бямба	Тасгийн боолт				

Тойролтын агуулга:

- Нүүрний анатоми, арьсны бүтэц үйл ажиллагаа.
- Нүүрний төрөлхийн болон олдмол эмгэг тэдгээрийг ялган оношлох.
- Арьсны эмгэгүүд, оношилгоо багажийн шинжилгээ.
- Шархны эдгэрэлт ерөнхий ойлголт
- Арьсны хавдрын урьдал өвчин, хортой болон хоргүй хавдар тэдгээрийг ялган оношлох.
- Арьсны эмгэгийн мэс засал болон мэс заслын бус эмчилгээний заалт.
- Арьсны хортой болон хоргүй хавдрын мэс засал эмчилгээний дараах нөхөн сэргээх мэс заслын аргууд.
- Хавдрын олон тэргэшлийн эмч нарын хамтарсан зөвлөгөө (Tumor board)

Оношлогоо эмчилгээний гардан үйлдэл, зайлшгүй сурах мэс засал

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
1. хамар-ходоодны хооллох гуурс тавих	20	Бие дааж хийх
2. шарх цэгцлэх, цэвэрлэх, угаах, урсгуур арчлах, шалгах, тавих, авах, далбан шалгах	100	Бие дааж хийх
3. Арьсанд оёдол тавих	100	Бие дааж хийх
4. Арьсанд зүслэг хийх	30	Бие дааж хийх
5. Арьсны далбан сөхөх	30	Бие дааж хийх
6. Чөлөөт арьс шилжүүлэн тавих	20	Бие дааж хийх
7. Хэсэг газрын арьсны далбан эргүүлэх	20	Туслах мэс засалч эмчээр
8. Чихний дэлбэнгийн шаантаг ба бүтэн тайралт, нөхөн сэргээлт	Тохиолдол бүрт	Туслах мэс засалч эмчээр
9. Дээд, доод зовхины өргөлт, таталт (canthoplasty)	Тохиолдол бүрт	Туслах мэс засалч эмчээр
10. Нүүрний хөнөөл ихтэй согогийг нөхөн сэргээх мэс засал	Тохиолдол бүрт	Туслах мэс засалч эмчээр

Зургаа. Үнэлгээ, эргэн зөвлөгөө

6.1. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрийг эмнэл зүйн сургагч багш удирдана. Суралцагч нь тойролт бүрийн эхэнд сургагч багштай уулзан тойролтын хуваарьтай танилцан тухайн тойролтод сурч эзэмшихээр зорьсон зорилтоо ярилцана. Тойролтын явцад зорилтондоо хүрэхэд дутагдаж байгаа болон нөхөх хэрэгцээтэй байгаа зүйлсээ ярилцана. Тойролтын төгсгөлд цаашид анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө авна.

6.2. Сургалтын алба

6.2. Үнэлгээний арга, төлөвлөгөө

Үнэлгээг дараах төлөвлөгөөний дагуу үнэлгээний аргаас хамааран эмнэл зүйн багш, тасгийн бусад эмч, сувилагч, өвчтөн, сургалтын албаны ажилтан, шалгалтын комисс хуваарийн дагуу хийнэ. Явцын үнэлгээний дүнг суралцагч эмчээс гадна сургалтын алба хадгалах ба эмнэл зүйн багш, сургалтын албанаас суралцагчид үнэлгээнээс хамааран цаашид сургалтыг амжилттай дүүргэхэд шаардлагатай зохих заавар зөвлөмжийг өгнө.

6.2.1. Үнэлгээний төлөвлөгөө

Зорилтууд	Үнэлгээний хэлбэр	Хамрах чиглэл	Арга, хэрэгсэл	Үнэлэгч/хэмжигч	Цаг хугацаа
1-6, 8	Явцын	Мэдлэг, чадвар	Дадлага: Mini-CEX, DOPS	Тасгийн эмч, эмнэл зүйн багш	Тойролт бүрт 5-8 удаа
7, 12, 13	Явцын	Мэдлэг, хандлага, багаар ажиллах чадвар	Дадлага: 360 хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	Тасгийн эмч, эмнэл зүйн багш, ахлах сувилагч, өвчтөн	Тойролт бүрт 1-2
9-10,13	Явцын	Хандлага, чадвар	Дадлага: 360 хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	Тасгийн эмч, эмнэл зүйн багш, өвчтөн	Тойролт бүрт 1-2
11, 12	Явцын, нэгдсэн	Хандлага, чадвар	Ажиглалт, аман: Ажиглалтын тэмдэглэл, бүтээлийн сангийн үнэлгээ, тайлан	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Сургалтын хугацаанд байнга ба төгсөлтийн өмнө
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Дадлага, онолын мэдлэг, Тайлан, төгсөлтийн шалгалт: тест, гардан үйлдэл	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Төгсөлтийн тестийн шалгалтын хамгаалалт буюу аман шалгалт	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт

6.2.2. Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace based assessment)

а) 360 хэмийн үнэлгээ (360 degree assessment)

Суралцагч эмчийн мэргэжилтний хувьд хэр "мэргэжлийн" (professional) байгааг үнэлэх зорилгоор сургалтын явцад тойролт бүрт үнэлнэ. Тойролт удирдсан багш нар болон сувилахуйн мэргэжилтэн, тасаг нэгжийн хамт ажилласан эмч, өвчтөн, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт таван хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүмүүсийг сургалтын албанаас томилох ба үнэлгээний дүнг суралцагч эмч болон эмнэл зүйн сургагч багшид танилцуулж үнэлгээнд үндэслэсэн цаашдын зөвлөгөөг эмнэл зүйн сургагч багш суралцагчид өгнө.

б) Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-CEX: Mini – Clinical Evaluation Exercise)

Эмнэл зүйд толгой хүзүүний эмгэгүүдийн хэсэг газрын шинж тэмдгүүдийг илрүүлэн таньж тойролт бүрт арваас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Хагалгааны дараах шархны эдгэрэл, хүндрэлийн шинжийг тойролт бүрт таваас доошгүй удаа үнэлнэ. Хорт хавдрын өвөрмөц эмчилгээний дараах бүтэц, үйл ажиллагааны алдагдлыг тойролт бүрт дөрвөөс доошгүй удаа үнэлнэ. Эмнэл зүйн үнэлгээ хийх эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

в) Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills)

Зайлшгүй сурах гардан үйлдлийн 80-аас багагүй хувийг бие даан хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

г) Бүтээлийн сангийн (Portfolio) үнэлгээ

Суралцагч эмч сургалтын хугацааны лекц, бие даалтаар хийсэн болон семинар, журнал клуб, сургалтын тойрон үзлэг зэрэг сурах хугацаандаа хийсэн сурсан, бүтээсэн зүйлсийн тайлан материалыг цуглуулан "бүтээлийн сан" болгон хадгална. Үүнд хариуцагч болон эмнэл зүйн багштай зөвлөлдсөн, зөвлөгөө авсан тэмдэглэл, эмч нарын зөвлөгөөнөөс сурч ойлгосон мэдлэгийн тэмдэглэл зэрэг мөн багтана.

6.3. Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг цаг тухайд нь авахуулж сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багшид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгалж, тойролт бүрийн төгсгөлд сургалтын албанд Mini-CEX ба DOPS үнэлгээний дүнг хүлээлгэж өгнө.

- Эмнэл зүйн багш ажиглан “ажиглалтын тэмдэглэл” хөтлөнө. Энэ тэмдэглэлд семинарийн идэвх оролцооны үнэлгээг болон явцын бусад дадлага ажлын үед ажиглагдсан, суралцагчийн цаашдын хөгжил дэвшилд хэрэг болохуйц гэж үзсэн санал, үнэлгээг тэмдэглэн оруулж болно.
- Сургалтын алба үнэлгээний дүнг суралцагч болон эмнэл зүйн сургагч багшид сургалтын нийт хугацааны дунд хагаст танилцуулах ба цаашид юунд анхаарах, төгсөх хүртэл юуг хийсэн байх талаар зөвлөгөө өгнө.

6.4. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Сургалтын хугацааны төгсгөлд “ажиглалтын тэмдэглэлүүд”-ийг эмнэл зүйн багшаас сургалтын алба авч нэгтгэн суралцагчийн хөгжил дэвшлийг үнэлэхэд мөн төгсөлтийн шалгалтын үнэлгээнд харгалзана.
- Тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын алба, эмнэл зүйн багшийн хамт гаргана. Үүнд тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэх шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
 - ❖ Зайлшгүй сургалтанд оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-иас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
 - ❖ Зайлшгүй таньж мэдэх 10 шинж тэмдгийн онцлог ялгах шинж тэмдгүүдийг 1 жилийн турш оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний болон оролцсон хагалгааны тохиолдлын тоо нь тойролт бүрийн хуваарьт тусгагдсаны дагуу байна.
 - ❖ Тойролтын дараа ба хагас жилээр эсвэл сургалтын хугацааны төгсгөлд суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон эмнэл зүйн сургагч багш тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.
- Сургалтын алба сургалт явагдсан тасгийн эмнэл зүйн сургагч багшийг оролцуулан бусад шалгалтын комиссыг бүрдүүлж төгсөлтийн шалгалтыг зохион байгуулна.

Долоо. Хэрэгжүүлэлт (Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх, хянах)

7.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт

- Суралцагчийн тоо, тойролтын хуваарийг эмнэл зүйн багшийн болон сургалт явуулах байгууллага, тасгийн үйл ажиллагаатай уялдуулан сургалтын алба хийнэ.
- Сургалтын эхэнд тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, эмнэлгийн үйл ажиллагаа, дотоод журам, эмчилгээ оношлогооны аюулгүй байдал, халдвар хамгаалалын талаарх гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг суралтын албанаас зохион байгуулна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын алба, сургалт явуулах байгууллага, тасгийн сургагч багш нартай хэлэлцэн нэмэлт өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

7.2 Хөтөлбөрийн хяналт

- Суралцах нийт хугацааны туршид хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн хөтөлбөрийн дүүргэлтийг сургалтын алба хянаж ажиллана.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш Сувилагч Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр бусдаас сонссон мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
-----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------

Үнэлэх боломжгүй	Ховор (≤ 19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (≥80%)
---------------------	------------------	----------------------	----------------------	----------------------

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	NA <input type="checkbox"/>	1 <input type="checkbox"/>	2 <input type="checkbox"/>	3 <input type="checkbox"/>	4 <input type="checkbox"/>
Эмнэлгийн бичиг баримтыг гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.					
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.					
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.					
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.					
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ ахиулахын тулд бие дан суралцдаг.					
Эмнэлгийн бусад тасгийн эмч нартай хамтран ажилладаг.					
Эмнэлгийн доторх туслаж, үйлчилгээнд зохон байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.					

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр найдваргүй” гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт нь “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубын 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй”.

Өөрөөсөө асуу: “ Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?”

Хавсралт 2

Эмнэл зүйн MiniCEX үнэлгээний хуудас

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Үнэлгээ хийсэн газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөө

Өвчтөний нас _____ Хүйс Эр Эм

Үнэлэх шинжүүд буюу өвчтөний зовиур: Халуурах Турах Цус алдалт, хуралт Өвдөх
 Хаван Тунгалагийн булчирхайн томрол Саа саажил Амьсгал бачуурал Дуу сөөх
 Бамбай булчирхайн томрол Арьсны шарх, мэнгэ Сорви, наалдац

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухайн үед суралцагч эмчийн түвшинг ажигласнаа үнэлнэ үү. Бодит үзлэг хийх шардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү. <input type="checkbox"/>				Сайжрахын тулд хийх үйлдэл
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	
Өвчний түүх нээх				
Бодит үзлэг				
Оношлогоо, эмчилгээний менежмент				
Харилцааны ур чадвар				
Эмнэл зүйн ерөнхий чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Хангалттай гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд	
Өвчний түүх авах, нээх	<ul style="list-style-type: none"> ▪ Ялган оношлогоо хийхүйц дэлгэрэнгүй авах ▪ Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу өгдөг ▪ Өвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> ▪ Ялган оношлогоо хийхүйц дэс дараатай бодит үзлэг хийдэг ▪ Үзлэгийн үед өвчтөнд таатай байх орчныг бүрдүүлдэг
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> ▪ Зөв онош тавьдаг. ▪ Шаардлагатай шинжилгээг зөв төлөвлөж эмчилгээнд ашигладаг. ▪ Тохирсон эмчилгээг эхлүүлдэг ▪ Шаардлагатай бол тохирсон тасагт шилжүүлдэг
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> ▪ Өвчтөн, түүний ар гэрийг сайн сонсдог. ▪ Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчийн зовнилыг хуваалцан ойлгож хүндэтгэлтэй ханддаг. ▪ Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчтай эелдэг, энгийн үгээр харьцдаг
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> ▪ Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг. ▪ Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрнө.

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS) ҮНЭЛГЭЭ

Нүүр ба арьсны эмгэг

Он сар өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөө

Гардан үйлдэл (доогуур нь зур): Үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх, эдийн шинжилгээ авах, Арьсны хортой болон хоргүй хавдар тайрах. Шарх цэгцлэлт, оёдол тавих, боолт эмчилгээ хийх.

Оролцсон хагалгаа: Хэсгийн мэдээ алдуулалттай болон ерөнхий мэдээ алдуулалттай мэс засалд оролцох. Чөлөөт эд ба арьсны далбан шилжүүлэх мэс засал. Нээлттэй эдийн шинжилгээ авах мэс засал.

Одоог хүртэл хийсэн гардан үйлдлийн тоо _____

Үнэлгээ	Хангалт-гүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй /үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдварүйжүүлэх үйлдлийг хийдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлээ ойлгож тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай барим бичгийг гүйцэт хөтөлдөг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж: Сайн тал

Сайжруулах тал

Бусад санал:

Үнэлэгч: _____

Суралцагч: _____

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS) ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС - ТӨВӨНХ, ЗАЛГИУР

Он сар өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөө

Гардан үйлдэл (доогуур нь зур): Төвөнх, нармай шууд дурандах, Уян дурангаар биопси авах, Хамар-ходоодны хооллох гуурс тавих, Трахеостомын гуурс тавих, Дууны протез тавих, Шарх цэвэрлэх, боох; Үүсвэр, булчирхайнаас эд, эсийн шинжилгээ авах; Хүзүүг хэт авиагаар шалгах, Оёдол тавих, Яаралтай трахеостоми тавих, Гүний вений тромбозоос сэргийлэх антикоагулянт эмчилгээ, Хэсэг газрын үзлэгийн тэмтрэлтүүд: хортой хоргүй хавдрын үүсвэрийг эхний үзлэгээр ялган баримжаалах

Оролцсон хагалгаа: Төвөнхийн хэсэгчилсэн тайралт, Төвөнх нээх (laryngofissure) ба дууны нугалаас тайрах (cordectomy), Утгуур мөгөөрс авах; Төвөнх бүтэн тайрах, Залгиур төвөнхийг бүтэн тайрч авах, Цагаан мөгөөрсөн хоолой-улаан хоолойн шунт, Цагаан мөгөөрсөн хоолойг нөхөн сэргээх, Улаан хоолойн хүзүүний хэсгийг авах, Зенкерийн цүлхэн авах, Голт шалгах\өвчих, Крикофарингеал миотомии\миоэктоми, Цагаан мөгөөрсөн хоолойн нарийсал засах, Залгиурыг хэсэгчлэн болон бүтэн тайрах, Залгиурыг нөхөн сэргээх

Одоог хүртэл хийсэн гардан үйлдлийн тоо _____

Үнэлгээ	Хангалт-гүй	Завсрын	Хангалт-тай	Ажиглагдаагүй/үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдварүйжүүлэх үйлдлийг хийдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлээ ойлгож тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай барим бичгийг гүйцэт хөтөлдөг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж: Сайн тал

Сайжруулах тал

Бусад санал:

Үнэлэгч: _____

Суралцагч: _____